



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар

A/42

Сүхбаатар сум


Бэлтгэл үүрэгтний сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1.6, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1. 33 дугаар зүйлийн 33.1. 33.2, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/267 дугаар тушаал, 2020 оны н/03 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайдын Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Цэргийн дайчилгааны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 10 хоногийн хугацаанд Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсугай.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын тушаалын хавсралтаар батлагдсан дайчилгааны бэлтгэл үүрэгтэн нэг бүрд зарлан дуудах хуудас хүргүүлэн 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 15.00 цагт сургалтад хамрагдах бэлтгэлийг хангуулан бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Сургалтын зардалд шаардагдах 7619570 /долоон сая зургаан зуун арван есөн мянга таван зуун дал/ төгрөгийг Батлан хамгаалах яамны санхүүжилтээр авч, сургалтыг батлагдсан төсөв, хуваарийн дагуу зохион байгуулахыг Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер /дэд хурандаа Ч.Дамдинсүрэн/-т үүрэг болгосугай.
4. Сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар тасралтгүй ханган хяналт тавих, сургалтын үр дүн, тайлан мэдээ гарган танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /дэд хурандаа Б.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801204



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/41

Сүхбаатар сум

Бэлтгэл үүрэгтний сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1.6, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/267 дугаар тушаал, 2020 оны н/03 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайдын Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Цэргийн дайчилгааны нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 10 хоногийн хугацаанд Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын тушаалын хавсралтаар батлагдсан дайчилгааны бэлтгэл үүрэгтэн нэг бүрд зарлан дуудах хуудас хүргүүлэн 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 15.00 цагт сургалтад хамрагдах бэлтгэлийг хангуулан бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Сургалтын зардалд шаардагдах 5346380 /таван сая гурван зуун дөчин зургаа мянга гурван зуун наян/ төгрөгийг Батлан хамгаалах яамны санхүүжилтээр авч, сургалтыг батлагдсан төсөв, хуваарийн дагуу зохион байгуулахыг Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер /дэд хурандаа Ч.Дамдинсүрэн/-т үүрэг болгосугай.

4. Сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар тасралтгүй ханган хяналт тавих, сургалтын үр дүн, тайлан мэдээ гарган танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /дэд хурандаа Б.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801202